



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1344
танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИХ ИРГЭН
Б.МӨНХБОЛД ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Болормаагийн Мөнхболдын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Болормаагийн Мөнхболдын Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр

ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Болормаагийн Мөнхболдын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН 13 ДУГААР ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ

БОЛОРМАА ОВОГТОЙ МӨНХБОЛД

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот
2020 он



ИРГЭН ТӨВТЭЙ ТӨР

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч нийт хүн амын 45% нь оршин суудаг Сонгинохайрхан дүүрэгт хүн амын 10.1% оршин суудаг байна.

Хотын хүн амын амьдралыг зохицуулсан, иргэд оршин суугчиддаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх, иргэн өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

ЗОРИЛТ: Хорооны иргэдийн сурч хөдөлмөрлөх, бизнес эрхлэх, аюулгүй орчинд амьдрах, хүүхдэд ээлтэй ногоон “ЭКО” орчин, таатай амьдрах нөхцөлийг бий болгоно.

- Иргэдийн оролцоотой Орон нутгийн хөгжлийн сангаас хийж хэрэгжүүлэх ажлын саналыг авч, иргэн төвтэй хот, хороо болох нөхцлийг бүрдүүлнэ.
- Бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, бизнесээ тэлэх, ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж дэмжиж ажиллана.
- Архи, мансууруулах бодис болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллана.
- Сургуулийн насны хүүхдийн гооны өсөлтөнд тулгуурлан бүх шатны сургалтын байгууллагын дэд бүтэцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчин бий болгож чанартай үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- Өрхийн эрүүл мэндийн төвийг дэмжих бодлого санаачилна.
- Хорооны Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжиж ажиллана
- Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, ижил түвшинд хүргэхийг зорьж ажиллана.
- Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

...../Гарын үсэг/
БОЛОРМАА СВОГТОЙ МӨНХБОЛД

